



БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан¹)

ЭХ ОРОН РУУГАА БУЦСАНААР АМЬ НАС НЬ ЭРСДЭХ АЮУЛ БАЙГАА ГЭЖ ҮЗВЭЛ СОЛОНГОС УЛСЫН ИРГЭНШИЛ ОЛГОЖ БОЛНО

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2021 № 34345

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгож нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгчид нь Исламын Бүгд Найрамдах Пакистан улс (цаашид “Пакистан улс” гэх)-д гэрлэлтээ бүртгүүлсэн тус улсын харьяалалтай иргэд бөгөөд Бүгд Найрамдах Солонгос улс (цаашид “БНСУ” гэх)-д D-10 визний зөвшөөрөлтэйгөөр хууль ёсоор амьдарч байх үедээ хүүхэдтэй болсон байна. Нэхэмжлэгч А, Б нар нь БНСУ-ын визний хугацаа дуусахаас өмнө тус улсад “дүрвэгчээр хүлээн зөвшөөрөх” хүсэлт гаргасан боловч Инчон хотын гадаадын иргэн, харьяатын газар татгалзсан хариу өгчээ. Нэхэмжлэгчид нь тухайн шийдвэрийг хүчингүй болгуулахаар дээд шатны албан тушаалтан болох Ерөнхий сайдад гомдол гаргасан боловч мөн татгалзсан хариу авснаар шүүхэд ханджээ.

Нэхэмжлэгчид шүүхэд гаргасан тайлбартаа: “Бид өөр овог, нийгмийн өөр давхарга хэдий ч хайр сэтгэлийн холбоотой болж, гэр бүлийн эсэргүүцлийг үл тоон гэрлэсэн. Үүнээс үүдэн гэр бүлийн нэр хүндийг гутаасан гэх шалтгаанаар амь насаа алдах аюулд ороод байгаа ба эх орондоо буцаж очвол “хууль бусаар гэртээ хоригдох болон бие махбодын хүчирхийлэлд өртөх” нь тодорхой гэх айдастай, өөр газар нутагт амьдралаа ч гэсэн мөрдлөг, мөшгөлтөөс зугтах боломж байхгүй, Пакистан улсын хууль тогтоох байгууллагын хийдэл болон мөрдөн шалгах байгууллагын чадваргүй байдлаас болж өөрийн эх орноосоо хууль зүйн хамгаалалт авах найдвар бага гэж үзэн дүрвэгчээр хүлээн зөвшөөрөх хүсэлт гаргасан” гэжээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос:
https://slgodung.scourt.go.kr/dcboard/new/DcNewsViewAction.work?seqnum=23966&gubun=44&cbub_c ode=000200&pageIndex=1



Анхан шатны шүүхээс: Дүрвэгчдийн тухай хууль (сол: 난민법²)-ийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Дүрвэгчийн эрх зүйн байдлын тухай 1951 оны олон улсын гэрээ (сол: 난민의 지위에 관한 1951 년 협약³)-ний 1 дүгээр зүйл, Дүрвэгчийн эрх зүйн байдлын тухай 1967 оны протокол (сол: 난민의 지위에 관한 1967 년 의정서⁴)-ын 1 дүгээр зүйлд заасныг нэгтгэн дүгнэвэл, Ерөнхий сайд нь арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, тусгайлсан нийгмийн давхаргын гишүүн, нийгэмд эзлэх байр суурь, улс төрийн үзэл бодлоосоо шалтгаалан хавчлагад орсон болон орох эрсдэлтэй гадаадын иргэн, түүнчлэн дээрх шалтгаанаар хавчлагад өртөх аюултай гэх айдсаас үүдэн өөрийн эх орноос хамгаалалт авахаас татгалзсан, өөрийн эх орон руугаа буцах хүсэлгүй байгаа хүн дүрвэгчээр хүлээн зөвшөөрүүлэх тухай хүсэлт гаргасан бол Дүрвэгчийн эрх зүйн байдлын тухай гэрээнд заасны дагуу дүрвэгчээр тооцохоор заасан байна. Гэвч нэхэмжлэгчид нь дээрх хууль болон гэрээнд заасан дүрвэгч гэх тодорхойлолтод хамаарахгүй. Учир нь гэр бүлийн эсэргүүцлийг үл тоон гэрлэсэн гэдэг нь тухайн хувь хүний бодол бөгөөд гэр бүлийн бүх гишүүд бус зарим гишүүдийн зүгээс гэр бүлийн нэр хүндийг гутаасан гэж үзэж байгаа, түүнчлэн А болон Б нарыг “тусгайлсан нийгмийн давхаргын гишүүн” гэж үзэх нь учир дутагдалтай гэж үзээд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс: “Пакистан улс нь уламжлалт эцгийн эрхт гэр бүлийн тогтолцоотой, гэрлэлтийг гэр бүл хоорондын солилцоо болон худалдааны хэрэгсэл болгон ашигладаг олон тооны цусан төрлийн бүлгээс бүрддэг байна. Дээрх бүлгүүд нь эмэгтэй хүнийг өөрөө гэрлэх хүнээ сонгохыг ямар ч утгагүй зүйл гэж үздэг бөгөөд энэ үйлдэл нь гэр бүлийн нэр хүндийг унагаадаг, нэр хүнд унагасан эмэгтэйг гэмтээх /амь насанд халдах/ нь гэр бүлийн нэр хүндийг сэргээдэг гэдэгт итгэдэг” талаар шүүхийн шийдвэртээ тусгажээ.

Иймээс эхнэр болох Б нь Пакистан улсад эрт дээр үеэс дагаж, мөрддөг гэрлэлтийн зан үйл болон гэр бүлийн ёс заншлыг зөрчин өөрийн сонголтыг дагаж нийгмийн өөр давхаргын хүнтэй гэрлэсэн. Энэ гэрлэлтээс үүдэн гэр бүлийн болон адил овгийн хүмүүсийн хавчлага, хүчирхийлэлд өртөх, хүчээр гэрлэлт цуцлах, өөр хүнтэй гэрлэх, алагдах зэрэг аюултай нүүр тулах эрсдэлтэй, эх орныхоо хууль хяналтын байгууллагаас зүй ёсны хамгаалалт авна гэсэн найдвар бага тохиолдолд “тусгайлсан нийгмийн давхаргын гишүүн”-д хамруулан үзэх боломжтой байна гэж дүгнэсэн.

Мөн Пакистанд өөрийн сонголтоор гэр бүл болсон эмэгтэйгээс гадна түүний нөхөр болон хүүхэд нь нэр төрийн аллагын хохирогч болсон тохиолдол байдаг, нэхэмжлэгчид эх орон руугаа буцвал эхнэрийнхээ гэр бүлийн гишүүдийн хавчлагад өртөхгүй гэх баталгаа байхгүй байгаа тул нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй гэж үзээд нэхэмжлэгчдийг дүрвэгчээр хүлээн зөвшөөрч, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэжээ.

² 난민법 제 1 조, 제 2 조 1 항, 2016.

³ 난민의 지위에 관한 1951 년 협약 제 1 조, 1993.

⁴ 난민의 지위에 관한 1967 년 의정서 제 1 조, 1992.

